

Байнгын хорооны 2022 оны
16 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

# ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

## НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| **1.1** | **Эцгийн нэр:** Дугарсүрэн<br>**Ургийн овог:** Шарнууд<br>**Нэр:** Гүн-Үйлс<br>**Хүйс:** Эр<br>**Төрсөн он:** 1965<br>**Төрсөн газар:** Улаанбаатар<br>**Иргэний харьяалал:** Монгол Улсын иргэн<br>**Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:** Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүрэг, 2-р хороо, 5-р хороолол, 1А байр, 118 тоот |
| **1.2** | **Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал** |
| | Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизийн Үндэсний Зөвлөлийн гишүүн |
| **1.3** | **Иргэний харьяалал**<br>Монгол Улсын иргэн мөн эсэх - Тийм.<br>Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх - Үгүй. |
| **1.4** | **Боловсрол** |
| | - ЗХУ (хуучнаар)-ын Казаний Их Сургууль, Орос хэл, утга зохиолын анги. 1984-1989 он. Магистр. Диплом: ДВО 010013<br>- Улаанбаатар хотын Орос Хэлний Багшийн дээд сургууль. 1983-1984 он. |
| **1.5** | **Эрхэлсэн ажил** |
| | - “Төрт Ёс, Хаадын Сан” ТББ-ын тэргүүн. 2012 оноос одоог хүртэл<br>- “Монголын Утга Зохиол Судлалын Төв” ТББ-ын тэргүүн. 2003 - 2012 |

| | |
|---|---|
| | - “Титэм”, “Монгол Экспресс” сонины эрхлэгч 1997-2000<br>- Монголын Радиод утга зохиолын нэвтрүүлгийн редактор 1989-1992<br>(Бусад үед чөлөөт уран бүтээлч байв.) |
| **1.6** | **Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал**<br>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэх |
| | Үгүй. |
| **1.7** | **Эрүүгийн хариуцлага**<br>Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх |
| | Үгүй. |
| **1.8** | **Яллагдагчаар татагдсан эсэх**<br>Яллагдагчаар татагдсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/. |
| | Үгүй. |
| **1.9** | **Сахилгын шийтгэлийн талаар**<br>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. |
| | Үгүй. |
| **1.10** | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар** |
| | - “Төрт Ёс, Хаадын Сан” ТББ-ын тэргүүн. 2012 оноос одоог хүртэл<br>- “Монголын Утга Зохиол Судлалын Төв” ТББ-ын тэргүүн. 2003 - 2012 |
| **1.11** | **Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ**<br>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.<br><br>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br><br>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.<br><br>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, |

нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

**Жич:** Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.

ТҮҮХ, СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР

- Чингис Хаан: Эш хөргийг баримтлах их эзний дүр төрх
- Их хаадын зарлигийн дээжис
- Монгол Хаад: Намтар цадигийн зурагт цомог
- Монголын Нууц Товчоо: хуулмал болон барламал дэвтрүүд
- Монгол Хаад (хүүхдэд зориулсан зурагт цомог)
- Тэнгэрийн Зарлиг (түүхэн туужис)
- Тэнгри (өгүүллэг, туужис)
- Солонгон Хөндий (роман)
- Алтан ургийн хаадын зургийн цомог
- МОНГОЛ ЗАЯАТАН
- Монгол Хаад - нэгдмэл бахархал (бүрэн хэмжээний түүхэн баримтат кино)
- Монгол Хатад: Ээдрээт түүхийн тайлал (бүрэн хэмжээний түүхэн баримтат кино)

УДИРДСАН ТӨСӨЛ, ТОМООХОН БҮТЭЭЛҮҮД

- Монгол хаад: 11 боть түүхийн их шастир

НЭГДҮГЭЭР БОТЬ (Тэргүүн Бөлөг - ХҮН ГҮРНИЙ ХААД: Модун шаньюй, Үжүлү Жоди шаньюй, Үлэй Жоди шаньюй, Юй Худурши шаньюй, Пүнү шаньюй, Би шаньюй; Атиль хаан. Дэд Бөлөг - ХАМАГ МОНГОЛЫН ХААД: Хабул хаан, Амбагай хаан, Хотула хаан, Есүхэй баатар);
ХОЁРДУГААР БОТЬ (ЧИНГИС ХААН);

ГУРАВДУГААР БОТЬ (ИХ МОНГОЛ УЛСЫН ХААД: Өгэдэй хаан, Гүюг хаан, Мөнх хаан, Аригбөх хаан);

ДӨРӨВДҮГЭЭР БОТЬ (ЦАГАДАЙН УЛСЫН ХААД: Цагадай хаан, Доголон Төмөр);

ТАВДУГААР БОТЬ (АЛТАН ОРДНЫ ХААД: Зүчи хаан, Бат хаан, Сартаг хаан, Улаагчи хаан, Бэрх хаан, Мөнхтөмөр хаан, Тудамөнх хаан, Тулабуга хаан, Тогтоа хаан, Узбек хаан, Тогтамыш хаан);

ЗУРГААДУГААР БОТЬ (ИЛ ХААНТ УЛСЫН ХААД: Хүлэгү хаан, Абага хаан, Тэкүдер хаан, Аргун хаан, Гэйхату хаан, Байду хаан, Газан хаан, Өлзийт хаан, Абу Сеид хаан);

| | |
|---|---|
| | ДОЛООДУГААР БОТЬ (Тэргүүн Бөлөг - ИХ ЮАНЬ УЛСЫГ ЭСЭРГҮҮЦСЭН МОНГОЛЫН ЭВСЛИЙН ТОЛГОЙЛОГЧ ХАЙДУ ХАН; Дэд Бөлөг - МОНГОЛЫН ИХ ЮАНЬ УЛСЫН ХААД: Хубилай Сэцэн хаан, Төмөр хаан Өлзийт, Хайсан Хүлэг хаан, Аюурбарбад Буянт хаан);<br><br>НАЙМДУГААР БОТЬ (Тэргүүн Бөлөг - МОНГОЛЫН ИХ ЮАНЬ УЛСЫН ХААД (үргэлжлэл): Шадбал Гэгээн хаан, Есөнтөмөр хаан, Тугтөмөр хаан, Ринчинбал хаан, Тогоонтөмөр хаан; Дэд Бөлөг - УМАРД ЮАНЬ УЛСЫН ХААД: Аюушридара хаан, Төгстөмөр хаан; Гутгаар Бөлөг - ДӨЧИН, ДӨРВӨН ХОЁРЫН МОНГОЛ УЛСЫН ХААД: Энх Зоригт хаан, Элбэг хаан, Гүнтөмөр хаан, Өлзийтөмөр хаан, Дэлбэг хаан, Адай хаан, Тайсун хаан, Махагүргис хаан, Молон хаан, Мандуул хаан, Батмөнх Даян хаан);<br><br>ЕСДҮГЭЭР БОТЬ (Тэргүүн Бөлөг - МОНГОЛЫН ТҮМЭД ТҮМЭНИЙ ТЭРГҮҮН АЛТАН ХАН; Дэд Бөлөг - ДӨЧИН, ДӨРВӨН ХОЁРЫН МОНГОЛ УЛСЫН ХААД: Барсболд хаан, Боди Алаг хаан, Дарайсун хаан, Түмэн Засагт хаан, Буян хаан, Лигдэн хаан);<br><br>АРАВДУГААР БОТЬ (ЗҮҮНГАР ХААНТ УЛСЫН ХААД: Галдан Бошигт хаан, Цэвээнравдан хаан, Галданцэрэн хаан, Даваач хаан);<br><br>АРВАН НЭГДҮГЭЭР БОТЬ (БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ХААН БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТ)<br>Хаадын намтар цадигуудыг туурвисан: Түүхийн Ухааны доктор С.Бадарчи, Ж.Болдбаатар, Л.Ганбат, Г.Жамсран, С.Лочин, Б.Нацагдорж, А.Пунсаг, Ж.Урангуа, Н.Хишигт, Ц.Цэрэндорж, С.Цолмон, Х.Шагдар, Д.Энхцэцэг, Ц.Энхчимэг, Г.Эрдэнэчимэг; магистр Ч.Содбилэг, Б.Сэрчин, А.Төмөр-Очир; доктор Д.Цахилгаан; Г.Мэнд-Ооёо, Б.Номинчимэд, С.Товуудорж<br><br>- “Монгол хатад” 3 боть түүхийн шастир.<br><br>I БОТЬ (Алун гуа, Өэлүн эх, Бөртэ хатан, Есүй хатан, Хулан хатан, Алаха бэхи, Сорхагтани бэхи, Дөргэнэ хатан, Огуль Хаймиш, Хотолун гүнж, Өлзийт гоо, Самар гүнж, Сэцэг бэйж, Мандухай сэцэн, Юнгэн хатан, Абай хатан, Мадь тайгал хатан)<br><br>II БОТЬ (Ханджамц хатан, Гүнж хатан, Сайхан Жуй хатан, Пунцагролма хатан, Доржравдан хатан, Ану хатан, Сэтэржав хатан, Дармабал хатан, Уламбаяр хатан, Есөнлүн хатан, Турхан хатан, Эргэнэ хатан, Сарай Мульк хатан, Ак султан Ханике, Ханзаде бегум гүнж, Айша султан бегум зэрэг Цагадайн улсын хатад, дараа нь Борогчин хатан, Цэцэг хатан, Яйлак хатан, Тайдула хатан, Жаныке гүнж нарын Алтан Ордны хатад),<br><br>III БОТЬ (Илдүз хатан, Тогос хатан, Гүюг хатан, Өлзий хатан, Хутуй хатан зэрэг Ил хаант улсын 20-иод хатан, Монголын Юань Улсын 17 хатан, Корёо болон Манжийн үеийн 30 гаруй хатан)<br>Хатдын намтар цадигуудыг туурвисан: Түүхийн Ухааны доктор Л.Ганбат, Б.Нацагдорж, А.Пунсаг, Ж.Урангуа, Ц.Цэрэндорж, С.Цолмон, Д.Энхцэцэг, Ц.Энхчимэг, Г.Эрдэнэчимэг; магистр Ч.Содбилэг, Б.Сэрчин, А.Төмөр-Очир. |

| | |
|---|---|
| | - Алтан ургийн 36, Алтан ургийн бус 1, нийт 37 хааны хөрөг бүтээх төсөл Төсөлд оролцсон зураачид: Ч.Алимаа, Ц.Болд, С.Ганболд, Б.Насанцэнгэл, Ц.Отгонбаяр<br><br>- Чингис, Өгэдэй, Хубилай гурван их хааны сэнтийдээ заларсан, реалист уран зургийг том хэмжээгээр бүтээх төсөл / Зураач: А.Далантай<br><br>- Чингис хааны цээж баримал / Барималч: А.Далантай<br><br>- Чингис хааны төрийн бэлгэдэл / Зөвлөх: С.Дулам (доктор, профессор)<br><br>- “Монголын Нууц Товчоо” нэгэн дэлгэмэл нүүрнээ бэлтгэх төсөл.<br><br>- Монголын Нууц Товчоо: танилцуулга, толилуулга / Төрт Ёс, Хаадын Сан, Өвөр Монголын “Монголын Нууц Товчоо” Сурвалж Бичгийн Хүрээлэн<br><br>- Монголын Юань гүрнийг үндэслэгч, их хаан Хубилайн 800 жилийн ойг ёслон тэмдэглэх ЗГ-ын бүрэлдэхүүнд ажиллаж, ойн лого, сүлд зураг зэргийг биечлэн бэлтгэв.<br><br>- Монголын найман Богд<br>- Богд Хаан (8-р Богдын намтар цадиг)<br>- Монголын их хаад<br>- Богдын лүндэн<br>- Хаан Цадиг (түүхэн туужис) / Төсөлд оролцогчид: С.Пүрэв, Б.Өлзийсүрэн, Ч.Жанчивдорж, Б.Ойдов, До.Цэнджав, С.Оюун<br><br>- Хатан цадиг (түүхэн туужис) / Төсөлд оролцогчид: Б.Өлзийсүрэн, До.Цэнджав, С.Пүрэв, Ч.Жанчивдорж, Б.Ойдов<br><br>- Жанжин цадиг (түүхэн туужис) / Төсөлд оролцогчид: С.Пүрэв, Ч.Жанчивдорж, Б.Ойдов, Д.Төрбат, С.Батжаргал, До.Цэнджав, С.Оюун<br><br>- Тэнгэр хүлэгтэн (Уралдаанд шалгарсан түүхэн туужис)<br>- “Есөн Зууны Сонгодог Бадгууд” XIII-XXI зуун хүртэлх монгол туургатны яруу найргийн дээжис (Д.Гүн-Үйлсийн тайлбар, тодруулга бүхий эмхэтгэл).<br><br>ОРЧУУЛГА, ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР<br>- А.С.Пушкин: Шүлгүүд / Орос хэлнээс орчуулсан Д.Гүн-Үйлс, ариутган шүүсэн Ю.Н.Кручкин. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2007, -132н.<br><br>- А.С.Пушкин “Таашаалдаа зориулму” (А.С.Пушкиний хориотой байсан шүлгүүд) / Орчуулагч Д.Гүн-Үйлс, дизайнер М.Тэгшжаргал, зураач А.Далантай. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2009. |

- Эрин зууны дурлал (У.Шекспирийн сонетууд, А.Пушкиний шүлгүүд; ном, CD) / Орчуулагч, дуун өгүүлэгч Д.Гүн-Үйлс, Бит пресс, 2010 он.

- Мао Зэдун / түүхэн өгүүллүүд. / Зохиогч А.Панцов, Орос хэлнээс орчуулсан Д.Гүн-Үйлс, Х.Төмөр. Бит пресс, 2010 он.

- Нострадамус: Зөн билиг оршвой. / Д.Гүн-Үйлс. Улаанбаатар хот, Соёмбо Принтинг компани, 2005.

- Дэлхийд манлайлагчдын маркетинг / Зохиогчид Сливотски А., Моррисон Д. Орчуулагч Д.Гүн-үйлс, Ц.Нарангэрэл, редактор Д.Гүн-Үйлс. Улаанбаатар хот, Соёмбо принтинг ХХК, 2006.

- Монгол-Англи Толь / Д.Гүн-Үйлс. техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Бит пресс, 2010.

- Орчуулга, найруулга зүй (Англи хэлээр жишээлсэн онол, дадлага) / Утга зохиолын тухай яриа (шүүмж судлал) / Зохиогч Д.Гүн-Үйлс. техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Соёмбо Принтинг ХХК, 2008.

- Англи хэлний нууц товчоо (Англи хэл сурахад тохиолдох хүндрэл бэрхшээлүүдийг даван туулах арга зам) / Зохиогч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2006.

- Кембрижийн англи хэлний шинэ курс: Түлхүүр хариулт бүхий дадлагын ном 4 (Кембрижийн Хэвлэлийн газрын албан ёсны эрхтэйгээр) / Зохиогчид О'Саливан, Д. Сван, М, Уолтер, К. / Орчуулагч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. - Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2007.

- Англи хэлний өгүүлбэр зүй / Зохиогч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2007.

- Англи хэлний үг зүй / Зохиогч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2007.

- Англи монгол зэрэгцүүлсэн хэл зүй / Зохиогч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2007.

- Монгол герман яриан толь / Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Соёмбо принтинг ХХК, 2005.

- Монгол англи тайлбар яриан толь / Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Соёмбо принтинг ХХК, 2005.

- Англи яриан хөтөч / Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Соёмбо принтинг ХХК, 2007.

- English – Mongolian phrase - book (аудио CD-ний хамт) / Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2008.

- Би англиар ярьж чадна (аудио CD-ний хамт) / Д.Гүн-Үйлс, зураач А.Бат-Эрдэнэ, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Live Design XXK, 2006.

- Англи хэлийг алхам алхамаар (1) (4 ширхэг аудио CD-ний хамт) / зохиогч Н.А.Бонк, И.И.Левина, И.А.Бонк; орчуулагч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2008.

- Англи хэлийг алхам алхамаар (2) (3 ширхэг аудио CD-ний хамт) / зохиогч Н.А.Бонк; орчуулагч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2008.

- Англи хэлний алтан дүрэм / Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2008.

- Англи хэлний алтан ном / Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2010.

- Speak & Listen / эмхэтгэгч, зохиогч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2008.

- Төгс гэгээрсэн их багш Чин Хай / Асуулт, хариултууд. Орчуулсан Д.Гүн-Үйлс

- Нохой миний амьдралд. Зохиогч Чин Хай. Орчуулсан Д.Гүн-Үйлс.

- Төгс гэгээрсэн их багш Чин Хай / Зуун зууны хайр. Орчуулсан Д.Гүн-Үйлс

ХҮҮХДИЙН ЗОХИОЛ БОЛОН БУСАД

- Тэнгэрийн охин (өгүүллэг, туурь) / Зохиогч Д.Гүн-Үйлс, зураач Цом.Ганзориг, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK

- “Шижиртэн дуурсах үеийнхэн минь” (Алтан Үеийн зохиолч, уран бүтээлчдийн тайлбар бүхий зургийн цомог.) / Ерөнхий редактор, эрхлэн нийтлэгч Д.Гүн-Үйлс. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2017.

- Яруу найргийн тухай яриа / Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Соёмбо принтинг XXK, 2007 он.

- Яруу найргийн шинэ үе. / Ерөнхий редактор, эрхлэн нийтлэгч Д.Гүн-Үйлс. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2007.

- “Гайхамшгийн эрэлд” Телевизийн 10 цуврал кино зохиол. Баримтат уран сайхны, хүүхдийн бүтээл. Байгаль хамгаалах сэдэвтэй. / Зохиогч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2008.

- “Гайхамшгийн эрэлд” 10 цуврал комикс. (Байгаль хамгаалах сэдэв) / Зохиогч Д.Гүн-Үйлс, Зураач: А.Бат-Эрдэнэ, дизайнер М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг XXK, 2013.

| | |
|---|---|
| | 1-р дэвтэр Цэвэр агаар,<br>2-р дэвтэр Лус гуай,<br>3-р дэвтэр Бэлэг,<br>4-р дэвтэр Хотод айлчилсан цэвэр агаар,<br>5-р дэвтэр Нууц,<br>6-р дэвтэр Амьтадын хувцасны дэлгүүр,<br>7-р дэвтэр Супермен,<br>8-р дэвтэр Ойг хэн тарив?,<br>9-р дэвтэр Гайхмаар юм,<br>10-р дэвтэр Тогорууны өндөг.<br>- Амьтадын тухай цувралууд (Хойд туйлын амьтад, Европ тивийн амьтад, Африк тивийн амьтад, Ази тивийн амьтад, Австрали тивийн амьтад, Америк тивийн амьтад) / Д.Гүн-Үйлс, дизайнер М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2008.<br><br>- “Мазаалай” цуврал (англи, монгол хэл дээрх) / Зохиогч Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Соёмбо принтинг ХХК, 2008.<br><br>- “Мазаалай” цуврал (Хүүхдэд зориулан туурвисан Монголын болон гадаадын зохиолчдын шилдэг бүтээлийн дээжис) / Д.Гүн-Үйлс, техник редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, Мөнхийн үсэг ХХК, 2008.<br><br>- “Эверест” аудио тренинг / Зохиогч Д.Гүн-Үйлс, Оролцсон уран бүтээлчид: Монгол Улсын Соёлын Гавъяат Зүтгэлтэн Чулуунбат, Хаянхирваа, нэвтрүүлэгч Идэрчулуун, найруулагч Баярсайхан, Насандулам. Редактор М.Тэгшжаргал. Улаанбаатар хот, МУЗСТ, 40 минут.<br><br>- “Ёстой гоё ном” (Хүүхдэд зориулан туурвисан Монголын зохиолчдын шилдэг бүтээлийн дээжис) / Ерөнхий редактор, эрхлэн нийтлэгч Д.Гүн-Үйлс, дизайнер М.Тэгшжаргал, зураач А.Далантай. Улаанбаатар хот, Мөнхийн Үсэг ХХК, 2009.<br><br>- Амжилтанд хүрэх буян / Сонсдог ном, double CD, 2008.<br><br>- Ярьдаг цагаан толгой (монгол) / зохиогч Д.Гүн-Үйлс, БНХАУ, Шэнжений хэвлэлийн компани, 2015.<br><br>- Ярьдаг цагаан толгой (англи) / зохиогч Д.Гүн-Үйлс, БНХАУ, Шэнжений хэвлэлийн компани, 2015.<br><br>- Гоёхон Бүүжий / зохиогч Д.Гүн-Үйлс, Монголын Утга Зохиол Судлалын Төв, Мөнхийн Үсэг ХХК. 2017. |

| | |
|---|---|
| | Жич: Дээрх бүтээлүүдээс гадна түүх соёл, хэл, уран зохиолын чиглэлээр олон арван бүтээлийг Д.Гүн-Үйлс редакторлон толилуулжээ. Өдгөө хэвлэлд бэлэн болсон хэд хэдэн бүтээл буй. |

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **2.1** | Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/. |
| | Миний бие үндэсний түүх, өв соёл, утга зохиолын салбарт олон жил ажиллаж, Монголынхоо ирээдүй хойч үе болон ард түмнийг соён гэгээрүүлэх үйлсэд өөрийн мэдлэг чадвараа зориулж ирсэн билээ. МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлж буй гол үндэслэл нь тус байгууллагыг үндэсний нэгдмэл үнэт зүйл, эв нэгдэл, соёл гэгээрлийн гол цөм байлгахад өөрийн мэргэжлийн туршлага, иргэний байр суурийг зориулах эрмэлзэл юм. Өнөөдөр нийгэмд талцал хуваагдал ихсэж, үл ойлголцол газар авч буй энэ үед үндэсний телевиз, радио нь ард түмнийг соён гэгээрүүлэх, эв нэгдлийг хангах "гүүр" болох ёстой. Би вээр зохиолч, түүх соёлоо эрхэмлэгч хүний хувьд энэхүү үйл хэрэгт бодлогын болон агуулгын бодит хувь нэмэр оруулж чадна гэдэгтээ итгэлтэй байна.<br><br>МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн гишүүний чиг үүргийн хүрээнд дараах чиглэлүүдийг нэн тэргүүний зорилт болгон ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:<br><br>1. Телевиз, радиогийн үг хэллэг, орчуулгын чанарт онцгой анхаарал хандуулж ажиллана. МҮОНРТ бол монгол хэлний стандартыг тогтоогч байх ёстой. Нэвтрүүлэгчдийн үг хэллэг, киноны орчуулга, мэдээний найруулгад мэргэжлийн хяналт тавьж, эх хэлний дархлааг хамгаалахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.<br><br>2. Түүх соёлын чиглэлээр бэлтгэж буй контентын агуулгын үнэн зөв байдал, оюуны үнэ цэнийг хамгаалахад анхаарна. Хуурамч болон туйлширсан түүхэн тайлбараас ангид байж, үндэсний ой санамжийг зөвөөр төлөвшүүлэхэд чиглэсэн контентын бодлогыг дэмжинэ. Түүхийг зөвхөн дурсах биш, ирээдүйн хөгжлийн хөдөлгүүр болгох агуулгын шинэчлэлд анхаарна.<br><br>3. Олон нийтийн радио, телевизийн мэдээ, мэдээллийн хөтөлбөрүүд нь тэнцвэртэй, үнэн зөв, ёс зүйтэй байх зарчмыг баримталж, нийгмийн сэтгэл зүйг тогтвортой байлгахад чиглэсэн хариуцлагатай сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br><br>4. МҮОНРТ нь нийгмийг талцуулах бус, нэгтгэх үүрэгтэй. Гэр бүлийн үнэт зүйл, хөршийн холбоо, нийгмийн эерэг хандлагыг сурталчилсан нэвтрүүлгүүдийг нэмэгдүүлж, стрессгүй, ёс зүйтэй мэдээллийн орчныг бүрдүүлэхэд хяналт тавина. |

| | |
|---|---|
| | 5. Монголын түүх, соёлын гайхамшгийг дэлхий дахинд таниулах гадаад сурталчилгааны бодлогыг чанаржуулах. 'Монгол контент'-ийг олон улсын стандартад нийцүүлэн экспортлох боломжийг эрэлхийлэхэд зөвлөх.<br><br>Би вээр МҮОНРТ-ийг зөвхөн мэдээллийн хэрэгсэл биш, монгол хүний оюун санааны тусгаар тогтнолын нэгэн баталгаа гэж хардаг. Миний зорилго бол эфирийн цаг бүрийг үзэгчиддээ шинэ мэдээлэл хүргэх, ард түмнийг соён гэгээрүүлэх, эх орноо хайрлах үзлээр цэнэглэхэд чиглүүлэх юм. Түүхээ мэддэг, эх хэлээ дээдэлдэг, эв нэгдэлтэй үндэстнийг бүтээхэд МҮОНРТ-ийн үүрэг маш их. МҮОНРТ-ийг Монголын ард түмний оюун санааны нэгдмэл дархлааг хамгаалагч, жинхэнэ утгаараа "Олон нийтийн" байгууллага байлгахын төлөө хичээн ажиллах болно. |
| | |

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Дугарсүрэн

Өөрийн нэр: Гүн-Үйлс

Гарын үсэг:

2026 оны 3-р сарын 3